



Raul Delgado Concepcion:

The most precious thing of Cuba is its people

Раул Делгадо Консепсион:

Куба улсын үнэт зүйл бол хүн

Бүгд найрамдах Куба улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Раул Делгадо Консепсионтой товлосон цагтаа уулзахаар ирэв. Тус улсын ЭСЯ-ны байрыг “Хоёр орны дипломат харилцааны түүхийг өгүүлэх нэгэн өв” гэж болохуйц ажээ. Яг л уран зургийн галерейд орж ирсэн мэт сэтгэгдэл төрүүлэх энэ байшинд Кубын алдарт зураачид болох Сервандо Кабрера Морено, Фелипе Гонзалес, Барес Кронадо, Амелиа Пэлаэз, Вилфредо Лам нарын бүтээлүүд нүд баясгана. Харин эрхэм Элчин сайд Раул Делгадо Консепсионоос нарлаг Куба орон, тэндэхийн хүн ардын аж амьдрал, түүх, соёл, хөгжлийн бодлого гэх мэтчилэн асууж сонирхох зүйл үнэхээр олон байлаа.

I came to meet Mr. Raul Delgado Concepcion, Ambassador Extraordinary and Plenipotentiary of Cuba to Mongolia on appointment. The Cuban Embassy building can be said “as a heritage narrating the history of our two countries’ diplomatic relations”. The building producing an impression of a fine art gallery accommodates the ravishing paintings by Cuban famous artists Servando Cabrera Moreno, Felipe Gonzales, Bares Coronado, Amelia Pelaez and Wifredo Lam. Actually, I had many things to ask from Ambassador Raul Delgado Concepcion about sunny Cuba, its people’s life, history, culture, development policy and others.

-Дэлхийн газрын зураг дээрх хамгийн сонирхолтой орнуудын нэг нь Куба. “Кристофер Колумбын хөлөглөсөн хөлөг онгоц 1492 оны аравдугаар сарын 28-нд байгалийн үзэсгэлэн бүрдсэн энэ газарт ирснээр Куба улсын албан ёсны түүх эхэлдэг” гэж зарим эх сурвалжид өгүүлсэн нь бий. Харин Кубад хамгийн анх хөл тавьсан монгол хүн хэн юм бол. Та энэ талаар сонирхон судалж байв уу?

-Кристофер Колумб Америк тивийг нээхдээ анх хөл тавьсан арал нь Куба юм. Тэр цагаас эхлэн хүмүүс “Куба үндэстэн” гэж ярих болсон. Гэхдээ бид 3000 жилийн түүхтэй монголчуудаас хамаагүй залуу үндэстэн. Испаничууд Куба арлыг анх нээн илрүүлснээс хойш эхний 200 жилд тэнд аж төрж байсан индиан хүмүүсийг бүгдийг нь устгасан. Ийнхүү испани хүмүүс манай газар нутгийг эзэлж, колоничилсноос хойш Африкаас нэг сая орчим иргэдийг авчирч хөдөө аж ахуйн салбарт боолын хөдөлмөр эрхлүүлж байсан юм. Харин испани, африк хүмүүсийн дундаас гарсан эрлийзүүдийг

Cuba is one of the most attractive countries on the world map. Some historical sources report that the official history of Cuba started with arrival of Christopher Columbus’ ship in this picturesque land on 28th of October 1482. It is curious to know the first Mongolian who visited Cuba. Were you interested in it?

On discovery of the American continent, Christopher Columbus landed on an island which was Cuba. Since then people speak about “Cuban nationality”. However, we are much younger as a nationality compared to the Mongolian people with a 3000-year history. The Spanish people eliminated all local Indians in the first 200 years post discovery of the Cuba Island. In this way the Spanish people occupied our territory. After colonization they brought about 1 million people from Africa and made them slaves in agriculture. Mulattos whose parents are Spanish and African are called “Cuban nationality”. Also, at the beginning of 18th century Chinese migrated from Canton surroundings were brought to Cuba to

“Куба үндэстэн” гэдэг. Мөн XVIII зууны эхэн үед Хятадын Кантон орчмоос дүрвэсэн хятадуудыг авчирч, газар тариалангийн салбарт голчлон ажиллуулж байлаа. Тийм учраас Куба үндэстний дунд Хятад цустай хүмүүс багахан хувийг эзэлдэг. Ингээд XIX зууны эхэн үеэс ард түмний дунд “Бид Куба үндэстэн. Тиймээс тусгаар тогтносон улс үндэстэн болох ёстой” гэх хүсэл эрмэлзэл хүчтэй бий болж, испаничуудын колоничлолын эсрэг тэмцэж эхэлсэн. Улс орныхоо түүхийн талаар товчхон сонирхуулахад ийм байна. Харин таны асуусан зүйлийн тухайд сайн мэдэхгүй. Мэдээж хэрэг, XX зууны эхэн үеэс аялал жуулчлал хөгжиж, Кубын газар нутагт монгол хүн хөл тавьж байсан байх. Манай хоёр орон 1960 онд дипломат харилцаа тогтоосны дараа төр засгийн тэргүүнүүдээс эхлээд албаны хүмүүсийн айлчлал ихэссэн. Тэр дундаа 1970-аад оны эхэн үед бүр ч илүү идэвхжсэн юм. Тухайлбал, нам, төрийн удирдагч агсан Ю.Цэдэнбал 1973 онд Куба улсад айлчилж байлаа. Нэг ёсондоо, Монгол, Куба улс дипломат харилцаа тогтоосноос хойшхи хамгийн том айлчлал нь энэ болов уу. Хамгийн сүүлд Монгол Улсын Ерөнхийлөгч асан Ц.Элбэгдорж 2016 оны есдүгээр сард манай улсад албан ёсны айлчлал хийсэн.

-XXI зууны кубачууд хэрхэн амьдарч байна вэ, тэдний эрхэмлэж явдаг үнэт зүйл нь юу бол, уламжлалт ахуй, зан заншлаа орчин үетэй хэрхэн хослуулдаг вэ гэхмэтчилэн олон зүйл сонирхлыг маань татаж байна. Таны хувьд, энэ бүхэнд юу гэж хариулах вэ?

-Шинэ зууны Куба үндэстний үнэт зүйл бол хүмүүнлэг, энэрэнгүй, эв найрамдлыг эрхэмлэдэг, бусад улс гүрэнд хүндэтгэлтэй, найрсаг хандаж, тус дэмжлэг үзүүлэхэд оршино. Бид Испанийн колоничлолын эсрэг 300 жил, дараа нь Америкийн колоничлолын эсрэг тэмцэж байж эрх чөлөө, тусгаар тогтнолоо олж авсан. Кубад 1959 онд хувьсгал ялж, ард түмэн маань сурч боловсрох, эрүүл мэндийн үйлчилгээг авах бүрэн боломжтой нийгмийг бид цогцлоосон юм. Учир нь манай улсын үнэт баялаг бол куба хүн. Тийм учраас төр засгийн зүгээс ард иргэдээ эрдэм мэдлэгтэй, өндөр боловсролтой, хүнлэг энэрэнгүй болгон төлөвшүүлэхэд ихээхэн анхаарч ирсэн. Кубачууд халуун цустай хүмүүс. Өөрөөр хэлбэл, дуу, хөгжимд дуртай, хөгжилтэй, аз жаргалтай ард түмэн.

-Хэдийгээр тантай өмнө нь уулзаж байгаагүй ч “Тал бүрийн авьяастай, их мэдрэмжтэй,

engage them mainly in plantation. Thus, people of Chinese blood account for a little proportion among the Cubans. Since the inception of 19th century (war for freedom of Cuba 1868.10.10) our people began fighting against Spanish colonization. There was a strong wish among the people: “We are a Cuban nationality, therefore, we must become an independent state”. This is a brief history of our country. But I do not know well about the matter you asked me. Obviously, tourism developed since the early days of 20th century and Mongolians might visit Cuba. The diplomatic relations between our two countries were established in 1960. Since then visits by Mongolian officials, including state heads increased, moreover, were much intensified in mid 70s. For instance, the former state and party head Mr.Yu. Tsedenbal visited Cuba in 1973. It was the highest level visit since establishment of diplomatic relations between Mongolia and Cuba. Later, then-President of Mongolia Mr.Ts.Elbegdorj paid an official visit to Cuba in September 2016.

What is the living style of Cubans in the XXI century? I am interested in many things, including values, traditions of the people and how they combine old with new. Please tell us about it.

The new centenary Cuban nation values humane and compassionate friendship, friendly, respected and supportive relations with other nations. We gained our freedom and independence after 300 years fight against Spanish colonization and then fight against American colonization. In 1959 revolution won a victory in Cuba. A society was formed where people have possibility for education and universal health care system. The reason is that the precious thing of our country is the Cubans. The state and government give a close attention to development of knowledgeable, highly educated and human rights for the citizens. Cubans are hot-blooded. In other words, they are lively and happy people, who love songs and music.

I've not met you earlier. However, on reading your life story I've got an impression that you are a typical modern person with many-sided talent. You are a comparatively young diplomat. Why did you move from the engineering economic sector to the diplomatic service?

There is a Cuban folk proverb with a meaning “The kitten learns hunting a mouse”. My mother served in diplomatic service for many years.

цаг үргэлжид өөрийгөө хөгжүүлж байдаг, жинхэнэ орчин үеийн хүн байна даа” гэх төсөөлөл ажил, амьдралын намтар түүхтэй тань танилцах үед төрсөн. Дипломатчийн хувьд та харьцангуй залуу хүн шүү дээ. Инженер, эдийн засгийн салбараас энэ салбар руу яагаад хөрвөх болсон юм бэ?
-“Муурын зулзага хулгана агнахад л суралцдаг” гэсэн утгатай Куба ардын зүйр цэцэн үг байдаг л даа. Ээж маань олон жил дипломат алба хашсан. Тийм учраас би хэдийгээр инженер мэргэжил эзэмшсэн ч хар багаасаа дипломат алба, олон улсын харилцааг сонирхон судалдаг байсан. Ээжийгээ дагаж олон оронд очиж байсны дотор Хятад, Вьетнамд хүүхэд насаа өнгөрүүлсэн минь санаанаас гардаггүй юм. Багадаа орос сургуульд суралцаж байлаа. Тэгэхээр англиас гадна оросоор ярьдаг гэсэн үг. Мөн вьетнам, хятад хэл гадарлана.

-Кубын домогт хувьсгалч Фидель Кастро Жон Ленноны хөшөөг 2000 онд босгоход ихээхэн үүрэг гүйцэтгэсэн. Тэрээр Ленноныг “Хөгжмийн ертөнц дэх жинхэнэ хувьсгалч” хэмээн хүндэлдэг байжээ. Харин та хөгжмийн ямар урсгалыг таашаан сонсдог вэ?

-“Битлз” хамтлаг 1970-аад оны үед кубачуудыг байлдан дагуулж байлаа. Кубын ард түмэн тус хамтлагийн дурсгалд зориулж Гавана хотын Вэладо гудамжин дахь цэцэрлэгт хүрээлэнд Жон Ленноны хөшөөг босгосон юм. Тухайн үед хүйтэн дайн ид дэгдэж, “Битлз” хамтлагийнхны дуунуудын үг хүмүүст их нөлөөлдөг байсан. Дэлхийн улс орнуудад “Битлз” хамтлагийн хөшөөг босгосон байдаг ч төдий л олон биш. Харин манай улсыг зорин ирцгээсэн жуулчид Жон Ленноны хөшөөний дэргэд саатаж, гэрэл зургаа авахуулдаг нь уламжлал болсон сайхан үйл явдал юм.

-“Кубачууд АНУ-д 1959 оноос өмнө үйлдвэрлэсэн автомашинуудыг л эзэмших эрхтэй. Тэгж хуульчилсан байдаг” гэх юм. Энэ хэр бодитой мэдээлэл бол?

-Куба дахь автомашинуудын ихэнхийг 1940-1960-аад онд үйлдвэрлэсэн байдаг. Үүнээс гадна XIX зууны эхэн үеийн автомашинууд ч бий. Эзэд нь автомашинаа гамтай хэрэглэсний үр дүнд өнгө үзэмж, эд ангиуд нь яг анх үйлдвэрлэсэн үеийнхээрээ. Эдгээр автомашин өнөөдөр Куба улсын өнгө төрх, имижийг тодорхойлоход гол үүрэг гүйцэтгэдэг гэхэд болно. Иргэд маань автомашинаа хувьдаа эзэмшихээс гадна жуулчдад үйлчлэх эрхтэй. Манай улс 2016 онд гадаадын дөрвөн

Though I obtained a profession of engineering, I was more attracted by diplomatic service and international relations from early childhood as I grew up in the family of a diplomat. And I joined this field without return. I was in many countries together with my mother. Especially, China and Vietnam are unforgettable for me, since I spent my childhood in these countries. In childhood I studied at the Russian school. So I speak Russian, except English. Also, I get a general idea of the Chinese and Vietnamese languages.

Cuban legendary revolutionist Fidel Castro is said to have played a great role in erection of a monument to John Lennon in Cuba, 2000. He respected the singer as “a genuine revolutionist in musical world”. As for you, what kind of music do you prefer to listen?

The “Beatles” group conquered Cubans in 1970s like all other countries in the world. At that time a cold war was in its prime, and the mode and words of “Beatles” songs suitable for the given time had an influence upon people. In memory of the group the Cuban people erected a monument to John Lennon in Velado street garden in Havana. A monument to “Beatles” has been erected in world countries, but not that many. Tourists visiting our country stop near John Lennon’s monument and take photos, that being a nice traditional event.

They say that “Cubans are allowed to ride a car produced in America prior to 1959”. Is it accurate information?

Majority of cars in Cuba were produced in years from 1940 to 1960s. Thanks to careful use of cars by owners, their appearance and parts are maintained exactly as new. It can be said these cars play a key role in definition of Cuba’s image. Our citizens have the right to provide service for tourists with their car in addition to the personal use. Our country received 4,7 million foreign tourists in 2016. Obviously, the number of tourists will be more than 4 million in 2017.

In the recent years cars produced in the West, Japan or Korea race in the street of Ulaanbaatar city. And in Cuba cars produced in the 20th century are on road traffic. Do you feel as if you returned to the last century on coming home?

Oh yes, I do. Apart from those old cars, our country has modern cars, also. Driving in an old car, you have got a feeling of return to the past. In general, Havana city has much architecture recounting the ancient history. The old cars decorate Havana city - the favorite place for



сая гаран жуулчин хүлээж авсан. Харин 2017 онд жуулчдын тоо дөрвөн саяас ч илүү гарах нь тодорхой байна.

-Улаанбаатарын гудамжаар баруунд болон Япон, Өмнөд Солонгост үйлдвэрлэсэн сүүлийн үеийн автомашинууд давхилдаж байна. Тэгвэл Кубад ХХ зууны дунд үед үйлдвэрлэсэн автомашинууд замын хөдөлгөөнд оролцдог. Эх орондоо очоод энэ бүхнийг харьцуулахаар өнгөрсөн зуунд очсон мэт мэдрэмж төрдөг үү?
-Тийм мэдрэмж төрөлгүй яах вэ. Манай улсад тэдгээр автомашинаас гадна сүүлийн үеийнх нь ч бас бий. Гэхдээ хуучны автомашинд суухаар өнгөрсөн цаг үед очсон юм шиг санагддаг. Ер нь Гавана хот өнө эртний түүхийг өгүүлэх уран барилга олонтой. Гадаад, дотоодынхон зорин очих дуртай Гавана хотыг чимдэг нэгэн зүйл нь хуучны автомашинууд юм. Тус хот шинэ Гавана, хуучин Гавана гээд хоёр янз. Хуучин Гавана дахь барилга байшингууд, хүмүүсийнх нь амьдралын хэв маяг, машин тэрэг нь өмнөх зуунд яваа мэт сэтгэгдэл төрүүлдэг. Шинэ Гавана хотын тухайд, орчин үеийн хэв шинжийг агуулдаг юм.

-Өнөөдрийн байдлаар, Кубын иргэдийн хэдэн

foreign and domestic tourists. The city is divided into new Havana and old Havana. The buildings, style of life and cars found in old Havana produce an impression that you are in the previous century. And new Havana represents a modern feature.

As of today what percentage of the Cubans use a mobile phone? Please share statistics with us.
Fifty eight years ago the USA imposed economic, financial and trade sanctions against our country. All this has had a significant adverse effect on the trade and economic sector of Cuba. In 1959 the revolution won the victory in Cuba, truly. Its price is these sanctions. Due to it, our country faces a difficulty to be in step with modern development and advanced technique and technology. However, we are making every effort not to stay far behind development of humanity. Though we are unable to implement the latest advanced technologies immediately, the government pays a great attention to the sectors of education and health. Cuba's population is 11 million. Of them, three or four million people use a mobile phone. A mobile network is introduced in 90 per cent entire territory of the country. In addition, 400 thousand

хувь нь гар утас хэрэглэж байгаа вэ?

-АНУ 58 жилийн өмнө манай улсад худалдаа, эдийн засгийн хориг арга хэмжээ авсан. Энэ бүхэн Кубын худалдаа, эдийн засгийн салбарт ихээхэн сөрөг нөлөө үзүүлсээр ирлээ. Кубад 1959 онд асар их үнээр хувьсгал ялсан. Тэр бүхний төлөөс нь энэхүү хориг арга хэмжээ юм. Үүнээс болж манай улс орчин үеийн хөгжил, техник, технологийн дэвшлээс хоцорч яваа. Гэлээ гээд бид зүгээр суугаагүй. Хүн төрөлхтөний хөгжлөөс хол хоцрохгүйн тулд бүх талаар хичээж байгаа. Сүүлийн үеийн дэвшилтэт технологиудыг шууд нэвтрүүлж чадахгүй байгаа ч боловсрол, эрүүл мэндийн салбарт Засгийн газрын зүгээс маш их анхаардаг. Куба улс 11 сая хүн амтай. Тэдгээрээс 3-4 сая хүн гар утас хэрэглэж байна. Манай улсын нийт нутаг дэвсгэрийн 90 хувьд үүрэн холбооны сүлжээ нэвтэрсэн. Түүнчлэн нэг сая хүн тутмын 400 мянга нь интернэт хэрэглэх боломжтой. Сүүлийн үед хүмүүс олноор цуглардаг газруудад утасгүй интернэт суурилуулж байгаа.

-Куба улсын эдийн засгийн салбарын гол хөшүүрэг нь элсэн чихэр, кофе, какао, зөгийн бал, ром, цитрусын төрлийн болон тамхины ургамал тариалалт. Тэдгээрийн хэдэн хувийг эцсийн бүтээгдэхүүн болгож экспортолдог вэ?

-Асуултад нэр дурдсан бүтээгдэхүүнүүд экспортын орлогоороо улсын төсөвт зонхилох хувийг эзэлдэггүй. Элсэн чихрийн тухайд, 1970-аад онд манай улсын эдийн засгийн ихэнх хувийг эзэлдэг байсан. Тэр үед нийтдээ долоон сая орчим тонн элсэн чихэр үйлдвэрлэдэг байв. Гэвч дэлхийн зах зээл дээр элсэн чихрийн үнэ унаснаас болж, энэхүү бүтээгдэхүүнээс ашиг олох боломжгүй болоод зогсохгүй тариалалтын зардлаа ч нөхөж чадахгүй шахам болсон. Харин сүүлийн жилүүдэд Кубад ром дарс, навчин тамхи, цитрусын төрлийн бүтээгдэхүүнүүдийг арай ихээр үйлдвэрлэж, экспортолж байна. Гэхдээ манай улс нийт төсвийнхөө дийлэнхийг аялал жуулчлалаас олсон орлогоос бүрдүүлдэг. Мөн боловсон хүчнээ гадаадад экспортолж, төсөвтөө тодорхой хэмжээгээр хувь нэмэр оруулдаг юм.

-Танай улс никелийн нөөцөөрөө дэлхийд дээгүүрт бичигддэг. Сүүлийн үед аялал жуулчлалын салбараа ч нэн хурдацтай хөгжүүлж байгаа. Байгалийн баялгаа зөв зохистой ашиглах, аялал жуулчлалаас олох орлогыг нэмэгдүүлэх талаар төр засгийн зүгээс ямар бодлого хэрэгжүүлж байна вэ?
-Сүүлийн үед дэлхийн зах зээл дээр никелийн



persons per each million people can access to internet. Conditions are created for limitless use of internet network in health research and secondary schools, institutes and universities, all sorts of research centers, scientific academies, as well as by students, professors, scholars and researchers of the institutes. In the recent years wireless internet is installed in public places.

I think granulated sugar, coffee, cacao, honey, rum, citric and tobacco products are the main lever of Cuban economy. What is the percentage of final products in export?

The products mentioned in the question do not account for the greater proportion in budget by export income. Granulated sugar accounted for the greater proportion of the country's economy in 1970s. At that time the country produced about 7 million tons of sugar in total. However, a decline in sugar price at the world market resulted in impossibility to gain profit from this product, moreover, it was almost impossible to recover the planting costs. Since recent we produce and export more rum, cigars and citrus products. But most of our budget consists of income gained from tourism. Also, we export human resources to contribute to budget to some degree. From

үнэ ханш унаснаас болж, олборлолтын хэмжээ нь багассан. Дээр хэлсэнчлэн улсын төсвийн нийт орлогын ихэнхийг аялал жуулчлалын салбараас олсон орлого эзэлдэг. Тийм учраас энэ салбарыг хөгжүүлэхийн сацуу байгаль орчноо хамгаалж, онгон дагшин хэвээр нь хадгалж үлдэхийг илүүд үзэж байна. Кубын Засгийн газрын 81 дүгээр тогтоол гэж бий. Тэрхүү тогтоолыг аялал жуулчлалын салбарт болон байгаль хамгаалахад хатуу мөрддөг.

-Зарим улс хөгжлийн төлөвлөгөөгөө олон жилээр гаргаж, дэлхий нийтэд танилцуулж байна. Кубачууд эдийн засгийн ойрын болон хэтийн төлөвөө хэдэн жилээр тодорхойлсон бол?

-Бид эдийн засгийн тогтвортой хөгжлийг чухалчилдаг. Куба улс гурван жилийн өмнө эдийн засгийн хөгжлийн хөтөлбөрөө боловсруулж батлахын тулд 1000 гаруй хурал, цуглаан, зөвлөгөөнөөр хэлэлцсний үндсэн дээр “Куба улсын эдийн засгийг 2016-2021 он хүртэл хөгжүүлэх хөтөлбөр”-ийг Коммунист намын долдугаар их хурлаар 240 гаруй удирдамжийг хөгжлийн есөн зарчимд тулгуурлаж хөгжүүлнэ гэсэн зорилттойгоор баталсан юм. Зарим салбарыг 2030 он хүртэл хөгжүүлэх хөтөлбөр ч бас бий.

-Монгол, Куба улс дипломат харилцаа тогтоосноос хойш 57 жил өнгөрчээ. Бүс нутгаасаа Монгол Улстай дипломат харилцаа тогтоосон анхны орон бол Куба. Тийм ч учраас талын Монголыг Латин Америк, Карибын орнуудтай холбох гол гүүр болж ирсэнд монголчууд маань ямагт талархдаг. Таны хувьд, манай улсад 2016 онд Элчин сайдаар томилогдож ирснээс хойш багагүй хугацаа өнгөрлөө. Энэ хугацаанд хийсэн ажлуудаасаа бидэнд сонирхуулна уу?

-Монгол Улсад Элчин сайдаар томилогдож ирсэндээ би туйлын их баяртай байдаг. Манай хоёр орны дипломат харилцаа 57 жилийн түүхтэй. Тэр цагаас эхлэн Монголын оюутан залуусыг Куба улсын их, дээд сургуульд тэтгэлгээр суралцуулж ирсэн нь бидний найрсаг харилцааны нэгэн илрэл юм. Кубын Засгийн газраас өнгөрсөн хугацаанд 168 монгол залууст үнэ төлбөргүйгээр өндөр боловсрол эзэмшүүлээ. Шилжилтийн хүнд хэцүү цагт ч манай улс энэхүү тэтгэлэгт хөтөлбөрөө зогсоогоогүй. Кубад янз бүрийн чиглэлээр суралцсан монгол залуус маань эх орныхоо хөгжилд хувь нэмрээ оруулж байгаа нь бидэнд бахархалтай санагддаг.

the state budget the 51% is used exclusive for education and health care system.

Your country comes out top of the world in its nickel resources. Recently, the country develops its tourist sector at a great speed. What policy is being implemented by the State in order to properly use the natural resources and to increase income from tourism?

In the last years the price for nickel has declined at the world market and its mining scale has reduced. As mentioned earlier, revenue gained from the tourist sector accounts for the greater part of public budget. Therefore, we give priority to protection of natural environment alongside with development of the tourist sector. There is a resolution No.81 issued by the Cuban government. Its provisions are strictly followed in the tourist sector and in preservation of nature.

Some countries elaborate a multiyear development plan and introduce it to the world. For how many years has Cuba developed its short-term and long-term economic plan?

We consider a stable economic development as important. Cuba has developed a development economic program. Three years ago we had more than 1000 consulting meetings among the population to develop and to have this program approved. We approved the program with an aim “to develop the Cuban economy up to 2016-2021 basing on the guide line economic principles of more than 274 guidelines approved in the 7th Congress of the Communist Party of Cuba”. Also, there are programs for some other sectors to develop up to 2030.

Fifty seven years passed since establishment of diplomatic relations between Mongolia and Cuba. Cuba was the first country from the region, which established diplomatic relations with Mongolia. So Mongolians are grateful to Cubans serving for Mongolia as a bridge for Latin American and Caribbean countries. You were posted to Mongolia as Ambassador in 2016. Not a little time passed since then. Could you tell us about your undertakings during this period?

I am very pleased to have been posted to Mongolia as Ambassador. Our two countries' diplomatic relations have a 57-year history. Since then young Mongolians study at universities and institutes in Cuba, and it demonstrates our friendly relations. In the past the Cuban government provided high education to 168 young Mongolians free of charge. Our country

-Танай улсад яг одоо хэчнээн монгол оюутан суралцаж байна вэ?

-Өнөөдрийн байдлаар, Куба улсад 23 монгол оюутан суралцаж байна. Тэднээс 21 нь анагаах ухааны, үлдсэн хоёр нь экспорт, аж үйлдвэрлэлийн чиглэлээр суралцаж байгаа. Куба улсын Засгийн газраас Монголд жил бүр 2-3 тэтгэлэгт хөтөлбөр зарладаг юм.

-“Кубад боловсрол эзэмшсэн монголчууд, бас Монголд их, дээд сургууль төгссөн кубачууд” гээд яривал хоёр орны харилцаа, хамтын ажиллагааны түүхийн талаарх сонирхолтой баримт олон бий. Нөгөөтэйгүүр Кубын эрүүл мэнд, энэ салбар дахь сургалтыг “Чанартай” гэх нэгхэн үгээр тодорхойлдог хүмүүс ч бий. Үнэхээр Кубын боловсрол, эрүүл мэндийн салбарын боловсон хүчин, үйлчилгээ өндөр түвшинд үнэлэгддэгийн нууц юу вэ?

-Куба улсын Засгийн газар ард иргэдийнхээ боловсрол, эрүүл мэндийн асуудлыг эн тэргүүнд тавьдаг. Тиймээс улсын төсвийн 50-аас дээш хувийг зөвхөн боловсрол, эрүүл мэндийн салбарт зарцуулж байна. 2017 оны байдлаар, улсын төсвийн 28 хувийг боловсрол, 23 хувийг эрүүл мэндийн салбарт зарцуулахаар тусгасан. Манай улсад дэлхийн өнцөг булан бүрээс 19 мянган оюутан залуус үнэ төлбөргүйгээр суралцаж байна.

-“Куба улсад элэгний В, С вирустэй нэг ч хүн байхгүй, чихрийн шижин өвчнийг эмчлэх бүтээгдэхүүн гаргаж авсан” гэж сонслоо. Эдгээр эм бэлдмэлийг Монголд нийлүүлж эхлэх талаар хоёр тал яриа хэлцэл хийж эхэлсэн үү?

-Манай улс эрүүл мэндийн салбараас олох ашиг орлогод бус, ард түмнийхээ эрүүл мэндэд дээд зэргээр анхаардаг. Иргэдийнхээ эрүүл мэндэд чиглэсэн хөтөлбөрийн хүрээнд хэрэглэж буй эм бэлдмэлүүдийн 80 хувийг бид дотооддоо үйлдвэрлэж байна. Ийнхүү найдвартай, чанартай бүтээгдэхүүн үйлдвэрлэхийн тулд эм, био бэлдмэлийн талаарх цогц бодлогыг хэрэгжүүлж, туршилт, судалгааны төвүүдийг олноор байгуулсан. Манай улсад “БИОФАРМАКУБА” гэдэг групп бий. Тус групп нь нийтдээ эмийн 38 үйлдвэрийг өөртөө нэгтгэсэн. Эдгээр үйлдвэрт дотоодын хэрэгцээний эм бэлдмэлүүдийн 80 орчим хувийг үйлдвэрлэдэг. Харин таны асуусан зүйлийн тухайд би “Тийм” гэж хариулна. Куба улс 1992 оноос эхлэн элэгний В вирусийг устгах тусгай хөтөлбөр боловсруулж, ард түмнийхээ дунд хэрэгжүүлж эхэлсэн. Өнөөдрийн байдлаар,



did not stop this scholarship program even in a hard time of special period of the economic in Cuba during the 90s. We are proud that young Mongolians obtained different professions in Cuba are contributing to development of their country.

How many Mongolian students are studying in Cuba right now?

As of today there are 23 Mongolian students in Cuba. Of them, 21 students study medicine, 2 persons study in the field sport and industry. Cuba announces 2-3 scholarships for Mongolia per year.

Speaking of the history of our countries' cooperation, we have many interesting facts, including Mongolians who obtained high education in Cuba or Cubans graduated from universities and institutes in Mongolia. Some our people define education in the Cuban health sector in one word “effective”. Indeed, the Cuban health and education sectors' human resources and services are highly valued. What is the secret?

Cuba gives priority to education and health of its populations. So the country spends 51 percent of budget exclusively on education and health sectors. As of 2017, 28 percent budget is allocated to education and 23 percent to health. Additionally

манай улсад В вирустэй хүн байхгүй. Чихрийн шижин өвчний эсрэг мөн л зорилтот хөтөлбөр хэрэгжүүлж, эмчилгээний чанарыг өндөр түвшинд хүргэлээ. Энэ өвчний улмаас маш олон хүндрэл гардаг. Тэдгээрийн нэг нь хөлийн шархлаа юм. Үүнийг эмчлэх бүтээгдэхүүнийг Куба улсад анх гарган авсан. Нэр дурдсан өвчин эмгэгээс гадна хорт хавдрын эсрэг эм бэлдмэл гаргах судалгаа шинжилгээний ажлуудыг амжилттай хийж, бүтээгдэхүүнээ үйлдвэрлэж байна. Кубад үйлдвэрлэсэн дээд зэргийн чанартай эм бэлдмэлүүдийг бид ЭМЯ, хувийн компаниудтай хамтран Монголын зах зээлд нийлүүлэх талаар шаргуу ажиллаж байгаа.

-Монгол, Кубын Засгийн газар дээд боловсролын сургалтын хөтөлбөр, диплом, эрдмийн зэргийг харилцан хүлээн зөвшөөрөх тухай хэлэлцээрийг 2017 оны зургадугаар сард байгуулсан. Энэ талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгнө үү?

-БСШУС-ын сайд Ц.Цогзолмаатай саяхан уулзаж, энэ талаар ярилцлаа. Тэрбээр “Энэхүү хэлэлцээрийг байгуулсан нь хоёр улсын түүхэнд тэмдэглэгдэн үлдэх маш том алхам юм” гэж онцолсон. Дээд боловсролын сургалтын хөтөлбөр, диплом, эрдмийн зэргийг харилцан хүлээн зөвшөөрснөөр монгол оюутнууд маань Кубад суралцаад эх орондоо эргэн ирж шууд ажиллах боломж бүрдэж байгаа юм. Монгол Улсын БСШУСЯ нь маш олон салбарыг хариуцдаг. Тус яамныхантай бид урлаг, спорт, шинжлэх ухааны салбарт олон ажлуудыг хамтран хийхээр ажиллаж байна. Биеийн тамир, спортын газрын дарга Ц.Шаравжамц болон бусад төлөөлөгч саяхан манай улсад биеийн тамир, спортын их хуралд оролцлоо. Энэ үеэр хоёр тал хамтран ажиллах төлөвлөгөөгөө баталсан.

-Нарлаг Куба орны иргэдийг бид аз жаргалтай инээмсэглэл, гитар хөгжмийн аялгуу, мамбо, ча ча бүжгээр төсөөлдөг. Кубын ард түмний бахархал, энэ орны имиж бол яах аргагүй дуу, бүжиг. Үнэндээ ардчилсан орны иргэд ч гудамжиндаа дуулж, бүжиглэхээс бараг ичдэг байхад кубачууд үндэсний өв соёлоороо бахархаж, уянгалаг дуу, хөгжим, бүжгээрээ хол, ойрын гийчдийг урин дуудаж чаддагаараа эрх чөлөөтэй. Энэ бүхнээс та ямар таашаалыг мэдэрдэг вэ?

-Кубачууд дууч, бүжигч, хөгжимд үнэнхүү дуртай ард түмэн. Дэлхийн улс түмэн энэ улс үндэстнийг ард түмнийх нь цовоо цолгин дүр төрх, аз жаргалтай инээмсэглэлээр нь

our country provides free education to more than 19000 students from many countries at sponsorship.

I've heard “there are no people with hepatitis B and C virus, and you've produced a medicinal preparation for treatment of diabetics”. Is there any discussion going on as for delivery of this preparation to Mongolia?

Our country pays a great attention to the people's health, but not to profit from health sector. We produce 80 percent of medicinal preparations used within citizens' health program domestically. To produce reliable products of good quality, we implemented a comprehensive policy on medicaments and bio preparations, set up experimental and research centers in numbers. In our country operates a group called “BIOCUBAFARMA”. This group integrates 38 pharmaceutical enterprises in total. These enterprises produce about 80 percent of medicinal preparations for home requirements. As far as your question is concerned, I say “yes”. Cuba developed a program to eradicate hepatitis B virus and began implementing it among populations since 1992.

As of today, there are no people with B virus. Also, we implemented a program against diabetics and achieved a high standard treatment. This disease causes many complications. One of them is foot ulcer. Cuba produced a medicine to treated it, first. Apart from the mentioned disease, we had successful researches in production of a medicinal preparation against cancer tumor and are manufacturing medicinal products. We are working on delivery of high quality medicinal preparations to the Mongolian market in cooperation with the higher institution from this sector and private companies.

The Mongolian and Cuban governments concluded an agreement on mutual acceptance of a high educational program, diploma and higher degree in June 2017. Would you tell us about it?

Recently, I met Mrs. Ts.Tsogzolmaa, Minister of Education, Culture, Science and Sport, and discussed about the matter. She stressed: “Conclusion of this agreement is a very big step to be recorded in history of our countries”. The mutual acceptance of a high educational program, diploma or higher degree creates possibility for Mongolian graduates in Cuba to be employed on return home, immediately. Ministry of education, culture, science and sport of Mongolia is in charge of very many fields. In cooperation with the Ministry we strive for arranging many activities in sectors of art, sport and science. A month ago Mr.



төсөөлдөг гэдэгт эргэлзэхгүй байна. Харин миний хувьд, монгол залуус куба дуу, хөгжим, бүжгээс суралцаж, янз бүрийн клубт хичээллэж байгаа нь сонирхол татсан. Хэдий алс хол оршдог ч гэлээ монголчууд Куба орны урлаг соёлоор амьсгалж, эрч хүчээ хөглөн эрүүл, аз жаргалтай амьдралынхаа нэгэн хэмнэл болгож чадсан нь сайхан санагдлаа. Монгол залуус Латин Америк бүжгийг маш гайхалтай бүжиглэж байна.

-Та манай улсад гэр бүлийнхэнтэйгээ хамт ирсэн үү. Танд болон эхнэр, хүүхдүүдэд тань Монголын өвөл, бас цас үлгэрийн оронд буй мэт сэтгэгдэл төрүүлж байгаа байх даа?

-Би Монголд эхнэр, хүүхдүүдтэйгээ хамт амьдарч байна. Танай улсын өвлийн өнгө төрх сэтгэлийг минь маш их татсан. Энэ өргөн уудам тал нутаг, байгаль дэлхийн гоо үзэсгэлэнг үнэхээр бахдмаар. Миний хувьд, дэлхийн олон оронд ажиллаж байсан. Тэр дундаа Монгол шиг сэтгэл татсан орон ховор. Би эх орныхоо байгалийн сайхныг биширдэг. Гэхдээ энэ газар орны зах хязгааргүй цэлийх тал яг л уртын дууг санагдуулна. Монголчууд маань байгалийнхаа ариун дагшин байдлыг энэ хэвээр нь хадгалж үлдээсэй гэж хүсдэг. Монгол орны өвөл маш хүйтэн. Харин би халуун орноос ирсэн. Хэдийгээр хоёр дахь өвлийнхөө нүүрийг үзэж байгаа ч айхтар даараад “Яасан

Ts.Sharavjamts, head of the Gymnastics & Sports Department, also other delegates participated in Gymnastics & Sports Congress in our country. During the visit the two parties adopted a plan on cooperation.

We imagine citizens of sunny Cuba smiling happily, playing the guitar, dancing mambo and cha cha cha. The Cubans' image is songs and dances, no doubt about it. They feel free to welcome guests with their melodious music and flexible dancing.

Indeed, the Cubans love singing, dancing and music. No doubt, the world nations imagine Cuba by its people's cheerful appearance and happy smile. However, it was interesting for me that young Mongolians learn Cuban and Latin American songs and dances, and take classes in different clubs. Mongolia is far from Cuba, however, Mongolians breathe with Cuban culture, inspire themselves and are able to make it a happy life style. I find it nice. Mongolian youth dance Latin American dances extremely well.

Did you come to Mongolia with your family? The snowy Mongolian winter may form unusual feelings on your wife and children.

In Mongolia I live together with my wife and children. The Mongolian winter is very exciting for me. A wide steppe and beauty of nature is really fascinating. I worked in many countries of the



хүйтэн юм бэ” гэж бодогдохгүй байна. Хамгийн их сэтгэл зовоож буй асуудал бол агаарын бохирдол юм. Энэ талаар дорвитой арга хэмжээ авахгүй бол ард иргэдийн эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж байгаа нь харамсалтай байна. Өнгөрсөн хугацаанд би зөвхөн Улаанбаатарт ажиллаагүй. Хөдөө орон нутгаар явж, хүн ардын аж амьдрал, ёс заншилтай танилцлаа. Эгэл ардуудын зочломтгой найрсаг зан надад үнэхээр гүн сэтгэгдэл төрүүлсэн.

-Бидний асуултад цаг зав гарган хариулсан танд болон ЭСЯ-ны хамт олонд талархаж байгаагаа илэрхийлье. Та бүхний ажилд амжилт хүсье!

С.Баттулга

world. Mongolia particularly fascinates me. Of course, I do admire beauty of my motherland. However, your country's limitless expanse of steppe makes me think the long song. I wish Mongolians to preserve virginity of land as it is. The climate in Mongolia is extreme, and the winter is very cold. I come from a hot country and experience my second winter here, but I do not get terribly cold and have never thought: "What a terrible cold!" Air pollution is an issue to be worried most. It is a pity that the problem has an adverse effect on population's health, unless effective measures are taken. In the past I have been not only in Ulaanbaatar. I went across the countryside to get acquainted with the local people's life and customs. I was greatly impressed by hospitality of ordinary people.

Ambassador, thank you and your colleagues at the embassy for the time. We wish success in your work!

S.Battulga




ТИЙЗНИЙ ЗЭЭЛ

Урьдчилгаа төлбөргүй

Та сард

90,000₮ төлөөд



ТОКИО-руу

нисэх боломжтой боллоо...

